

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхдийн төв номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/281/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 51261885 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитор: С.Билгүтэй Утас: 51260512 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn “Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл Утас: 99032466 Цахим хаяг: oyungerels.sag@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
ЗАХИРАЛ С.ХҮРЭЛБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/401
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын ажлын байрны түрээсийн төлбөрийг тайлант жилийн төсөвт бүрэн тусгаагүйгээс 114,236.2 мянган төгрөгийн өр үүссэн нь түрээсийн төлбөрийн өр хуримтлагдах, дараагийн жилийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учруулах эрсдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,545,358.00	66,772,994.00
35	БАРАА МАТЕРИАЛ	101,545,358.00	66,772,994.00
35100	Түүхий эд материал	20,966,848.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	20,966,848.00	0.00
35400	Хангамжийн материал	80,578,510.00	66,772,994.00
35410	Бичиг хэргийн материал	1,215,910.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	79,362,600.00	66,772,994.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	793,473,014.34	776,129,213.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	793,473,014.34	776,129,213.16
39200	Биет хөрөнгө	793,473,014.34	776,129,213.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	6,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(833,333.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	151,183,315.50	126,460,780.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,558,413.55)	(62,514,985.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	133,233,146.82	124,681,261.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(71,675,885.70)	(74,278,660.78)
39217	Ном	647,290,851.27	656,614,151.27
39301	Програм хангамж	4,179,100.00	4,179,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,179,100.00)	(4,179,100.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	895,018,372.34	842,902,207.16
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	132,817,183.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	132,817,183.00
41300	Өглөг	0.00	132,817,183.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	114,236,200.00
41360	Бусад өглөг	0.00	18,580,983.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	5,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	13,580,983.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	895,018,372.34	710,085,024.16
51	Засгийн газрын хувь оролцоо	895,018,372.34	710,085,024.16
51100	Засгийн газрын оруулсан капитал	398,693,113.63	398,693,113.63
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	398,693,113.63	398,693,113.63
51200	Хуримтлагдсан үр дүн	423,679,897.17	238,746,548.99
51210	Өмнөх үеийн үр дүн	352,354,023.27	423,679,897.17
51220	Тайлант үеийн үр дүн	71,325,873.90	(184,933,348.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,645,361.54	72,645,361.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	895,018,372.34	842,902,207.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,312,907,917.00	1,346,432,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,731,516.00	1,346,432,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,731,516.00	15,245,400.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,731,516.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,731,516.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	15,245,400.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	1,292,396,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0.00	1,292,396,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	38,790,400.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,560,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	34,230,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,300,176,401.00	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,188,158,200.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,188,158,200.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,018,201.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,900,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,118,201.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,205,248,401.60	1,531,366,048.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,205,248,401.60	1,531,366,048.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,180,539,400.60	1,404,769,684.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	792,864,563.00	812,886,500.00
210101	Үндсэн цалин	502,858,725.00	499,480,569.31
210102	Нэмэгдэл	116,172,428.00	125,499,026.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,918,007.00	113,761,400.00
210104	Урамшуулал	54,915,403.00	74,145,504.69
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	107,381,337.00	105,800,259.08
210201	Тэтгэврийн даатгалын зардал	75,372,537.00	72,155,059.08
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	7,015,600.00	8,411,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,987,700.00	4,205,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,001,100.00	4,205,700.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	16,004,400.00	16,822,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,943,200.00	248,400,000.00
210304	Байрны түрээс	136,943,200.00	248,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,632,960.00	83,308,264.00
210401	Бичиг хэрэг	6,325,810.00	9,191,095.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	786,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,638,800.00	1,770,055.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,368,350.00	71,561,114.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	8,137,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	6,797,700.00
210602	Тавилга	0.00	840,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,136,100.00	75,404,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,878,600.00	69,175,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,257,500.00	1,229,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,581,240.60	70,832,101.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	32,110,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,581,240.60	37,722,101.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,709,001.00	126,596,363.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,706,200.00	118,135,483.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,006,200.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	110,915,483.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	7,220,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,801.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,600.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	201.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	8,460,880.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	8,460,880.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	107,659,515.40	(184,933,348.18)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	36,333,641.50	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	36,333,641.50	0.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(36,333,641.50)	0.00
VIII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	71,325,873.90	(184,933,348.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,300,176,401.00	1,331,187,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,331,187,300.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	1,292,396,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0.00	1,292,396,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	38,790,400.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,560,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	34,230,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,300,176,401.00	0.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,188,158,200.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,188,158,200.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,018,201.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,900,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,118,201.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,223,063,601.00	1,326,054,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,223,063,601.00	1,326,054,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,198,354,600.00	1,191,439,019.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	800,218,500.00	812,886,500.00
210101	Үндсэн цалин	502,858,725.00	499,480,569.31
210102	Нэмэгдэл	116,172,428.00	125,499,026.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,918,007.00	113,761,400.00
210104	Урамшуулал	62,269,340.00	74,145,504.69
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	100,027,400.00	105,800,259.08
210201	Тэтгэврийн даатгалын зардал	68,018,600.00	72,155,059.08
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,002,200.00	8,411,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,001,100.00	4,205,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,001,100.00	4,205,700.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	16,004,400.00	16,822,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,943,200.00	134,163,800.00
210304	Байрны түрээс	136,943,200.00	134,163,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,163,600.00	14,888,700.00
210401	Бичиг хэрэг	641,300.00	4,339,845.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	120,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,638,800.00	1,770,055.00
210405	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	0.00
210406	Эд хогшил, урсгал засварын зардал	38,083,500.00	8,658,800.00
2106	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	8,500,100.00
210601	Тавилга	0.00	8,000,100.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,501,900.00	75,874,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,004,400.00	74,645,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,497,500.00	1,229,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	39,325,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	38,325,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,709,001.00	134,615,380.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,706,200.00	126,154,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,006,200.00	21,600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	97,334,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	7,220,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,801.00	0.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,600.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	201.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	8,460,880.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	8,460,880.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	77,112,800.00	5,132,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	77,112,800.00	5,132,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,112,800.00	5,132,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	77,112,800.00	5,132,900.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	5,132,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	77,112,800.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-77,112,800.00	-5,132,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/д	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	352,354,023.27	823,692,498.44
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	352,354,023.27	823,692,498.44
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	71,325,873.90	71,325,873.90
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	423,679,897.17	895,018,372.34
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	423,679,897.17	895,018,372.34
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-184,933,348.18	-184,933,348.18
7	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	238,746,548.99	710,085,024.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,387,128,700.00	1,290,553,919.08	(96,574,780.92)	93.0
12	Татварын бус орлого	1,387,128,700.00	1,290,553,919.08	(96,574,780.92)	93.0
122	Тусламжийн орлого	1,387,128,700.00	1,290,553,919.08	(96,574,780.92)	93.0
122005	Төсвөөс санхүүжих	1,387,128,700.00	1,290,553,919.08	(96,574,780.92)	93.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,387,128,700.00	1,290,553,919.08	(96,574,780.92)	93.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,387,128,700.00	1,290,553,919.08	(96,574,780.92)	93.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,258,578,800.00	1,164,399,419.08	(94,179,380.92)	92.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,886,500.00	812,886,500.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	500,298,800.00	499,480,569.31	(818,230.69)	99.8
210102	Нэмэгдэл	121,393,500.00	125,499,026.00	4,105,526.00	103.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	119,434,300.00	113,761,400.00	(5,672,900.00)	95.3
210104	Урамшуулал	71,759,900.00	74,145,504.69	2,385,604.69	103.3
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	107,642,600.00	105,800,259.08	(1,842,340.92)	98.3
210201	Тэтгэврийн даатгалын зардал	73,997,400.00	72,155,059.08	(1,842,340.92)	97.5
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,411,300.00	8,411,300.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,205,700.00	4,205,700.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,205,700.00	4,205,700.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	16,822,500.00	16,822,500.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,163,900.00	134,163,800.00	(100.00)	100.0
210304	Байрны түрээс	134,163,900.00	134,163,800.00	(100.00)	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	8,185,000.00	6,598,100.00	(1,586,900.00)	80.6
210401	Бичиг хэрэг	1,196,600.00	767,145.00	(429,455.00)	64.1
210402	Тээвэр, шатахуун	0.00	60,000.00	60,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,796,200.00	1,770,055.00	(26,145.00)	98.5
210404	Ном, хэвлэл	3,197,900.00	3,197,900.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,994,300.00	803,000.00	(1,191,300.00)	40.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,987,600.00	8,000,100.00	(55,987,500.00)	12.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	63,987,600.00	8,000,100.00	(55,987,500.00)	12.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,722,500.00	58,625,660.00	(25,096,840.00)	70.0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,246,600.00	57,396,600.00	(19,850,000.00)	74.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	0.00	(4,977,100.00)	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,498,800.00	1,229,060.00	(269,740.00)	82.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,990,700.00	38,325,000.00	(9,665,700.00)	79.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,990,700.00	38,325,000.00	(9,665,700.00)	79.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,549,900.00	126,154,500.00	(2,395,400.00)	98.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,549,900.00	126,154,500.00	(2,395,400.00)	98.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,995,400.00	21,600,000.00	(2,395,400.00)	90.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,334,500.00	97,334,500.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,220,000.00	7,220,000.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	
222001	Тоног төхөөрөмж	0.00	0.00	0.00	
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0.00	0.00	0.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21	26	5	123.8
620003	Үйлчлэх ажилтан	7	2	0	28.6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29	1	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	21	25	4	119.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	4	(4)	50.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	4	4	0	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	4	4	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	32,172,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,172,500.00
122	Тусламжийн орлого	32,172,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	32,172,500.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,172,500.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,560,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,612,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,172,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,172,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,172,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,423,500.00
210401	Бичиг хэрэг	3,572,700.00
210402	Тээвэр, шатахуун	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,790,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,249,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,249,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхдийн төв номын сан нь монгол, англи, герман, орос, хятад болон бусад хэлээр хэвлэгдсэн 90 гаруй мянган ном, хэвлэмэл бус материал, сурах бичиг, тогтмол хэвлэлийн сан хөмрөгийн хэмжээнд нийслэлийн хүүхэд залуучуудад номын сангийн үйлчилгээг үзүүлэх үндсэн үйл ажиллагааг явуулдаг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулиудыг баримтлан Номын сангийн тухай хуулийн дагуу Нийтийн номын сангаар үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг ба зөвхөн уншигчийн үнэмлэхийг жилд 6-18 насанд 3000 төгрөг, 18-аас дээш насны гадаад дотоодын иргэн, оюутан залууст 5000 төгрөгөөр олгож, үйлчилдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Сангийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Хүүхдийн төв номын санд дотоод аудиторын чиг үүрэг бүхий албан тушаалтан байхгүй бөгөөд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлант онд тус байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж, ирүүлсэн тайлантай танилцсан болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхдийн төв номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Соёлын сайд (хуучин нэрээр)-ын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан соёлын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг байна.

Тухайн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон буюу тус бодлогын баримт бичгийн 5.11.3-т “Номын сангийн байгууллагын бүртгэл, тайлагналын онцлог”-ийг тусгасан байна. Гэвч зарим

зүйл заалтыг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай нийцүүлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүүхдийн төв номын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,116.2 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Бараа материал	101,545.4	66,773.0	(34,772.4)
Үндсэн хөрөнгө	793,473.0	776,129.2	(17,343.8)
Нийт хөрөнгө	895,018.4	842,902.2	(52,116.2)
Өр төлбөр	-	132,817.2	132,817.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	895,018.4	710,085.0	(184,933.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	895,018.4	842,902.2	(52,116.2)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, өр төлбөр, Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ данснууд байна. Үүнд:

Өмнөх оноос Бараа материалын дансны үлдэгдэл 34,772.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд зохион байгуулагдсан “Нүүдэлчин” наадамд байгууллагын түүх дурсгалын өргөөг гаргах, бусад соёлын арга хэмжээнд зориулан 2024 онд нөөцөлсөн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс худалдан авсан 5,132.9 мянган төгрөг, номын фондод хандиваар бэлтгэсэн 6,125.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан автомашин 6,000.0 мянган төгрөг, компьютер, тоног төхөөрөмж 3,120.0 мянган төгрөг, нийт 20,378.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А-2/2407 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 38,329.4 мянган төгрөгийн балансын үнэтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 40 нэрийн хөрөнгийг акталж, данснаас хасжээ.

Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын гэрээний дагуу Нийслэлийн Соёлын төв өргөөний түрээсийн төлбөр нэмэгдэж, 1 м² талбайн сарын түрээс 9.0 мянган төгрөг буюу тухайн байгууллагын ашиглаж буй 2,300 м² талбайн түрээсийн жилийн төлбөр 248,400.0 мянган төгрөгийг төсөвт бүрэн баталж өгөөгүйгээс 114,236.2 мянган төгрөг, төсөвт батлагдсан боловч зарцуулалтын эрх нээгдээгүйгээс аудитын үйлчилгээний төлбөрийн 5,000.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарсан 2 ажилтанд дутуу олгосон тэтгэмж 13,581.0 мянган төгрөг, нийт 132,817.2 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн бол тайлант үеийн үр дүн (184,933.3) мянган төгрөгөөр Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурчээ.

Аудитын судалгаагаар тус байгууллагын санхүүгийн тайланд үндсэн үйл ажиллагааны буюу номын сангийн үйлчилгээний 1 цогц, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 4 модуль, нийт 4,179.1 мянган төгрөгийн балансын үнэтэй 5 програм байгаа нь бүгд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөж, үлдэх өртөггүй болсон хэдий ч 4 програмыг нь зориулалтын дагуу ашигладаг байна. Харин

төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн тооцооллыг Төрийн албаны цалингийн нэгдсэн системд холбосноор 275.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй “Payroll” програм ашиглагдахгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 2,183,902.9 мянган төгрөгөөр тооцон, улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 768,987.6 мянган төгрөгөөр бууруулж, төсвийг 1,414,915.3 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант оны батлагдсан төсвийг тодотголоор 27,787.6 мянган төгрөгөөр бууруулан төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг нийт 1,387,128.7 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,292,396.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогыг нэмэлт төсвийн дансаар төвлөрүүлэн зарцуулсан бөгөөд үлдэгдэл 1,843.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,290,553.9 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 8,676.4 мянган төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардал 19,850.0 мянган төгрөг, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт 68,048.4 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр (71702), арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал (80101)	1,045,358.6	1,036,682.2	(8,676.4)	99.2
2	Харуул хамгаалалтын зардал (80219)	44,876.6	44,876.6	0.0	100.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг (80802)	104,554.5	104,554.5	0.0	100.0
4	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх (81569)	32,370.0	12,520.0	(19,850.0)	38.7
5	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт (81855)	159,969.0	91,920.6	(68,048.4)	57.5
	НИЙТ ДҮН	1,387,128.7	1,290,553.9	(96,574.8)	93.2

Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангиллын “Соёл урлаг” хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,387,128.7 мянган төгрөгийн тодотгосон төсөв батлагдсанаас 3 арга хэмжээ бүрэн, 2 арга хэмжээ 38.7-57.5 хувийн биелэлттэй буюу хөтөлбөрийн дүнгээр 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: Тус байгууллагын захирлын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар нийт 32 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулж байснаас захирлын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар 3 орон тоогоор бууруулж, 29 орон тоотой ажиллаж байна.

Хоол, унааны хөнгөлөлт: Байгууллагын захирлын 2013 оны А/45 дугаар тушаалын дагуу ажилтанд ажлын 1 өдөрт хоолны 15.0 мянга, унааны 1.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг тус олгосноор тайлант жилд 119,434.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 113,761.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Төрд учруулсан хохирол: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 210/МА2025/00142 дугаартай магадлалаар “ажлаас буруу үндэслэлээр чөлөөлөгдсөн” 1 ажилтанд буруутай албан тушаалтан буюу байгууллагын захирал 13,301.7 мянган төгрөгийг төлөхөөр тогтоогдож, хувиараа тохиролцон сар бүр ижил дүнгээр төлбөрийг барагдуулдаг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 34,230.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4,560.0 мянган төгрөг, нийт 38,790.4 мянган төгрөгийн нэмэлт төсвийн эх үүсвэр бүрдүүлснээс бараа үйлчилгээний зардалд 32,172.5 мянган төгрөгийг зарцуулж, зөрүү 6,617.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүүхдийн төв номын сан тайлант онд 8 төрлийн 323,900.0 мянган төгрөгийн худалдан авалт хийх төлөвлөгөөний дагуу холбогдох талуудтай гэрээ байгуулсан боловч төсвийн хүрэлцээгүйгээс 209,663.8 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 204,663.8 мянган төгрөг буюу 97.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үндсэн хөрөнгийн болон өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Уламбаяр, аудитор Д.Энхбаяр нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал С.Оюунгэрэл, менежер Ж.Болормаа нар, дараагийн шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор С.Билгүтэй, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхдийн төв номын сангийн 2025 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны тодотголоор батлагдсан төсөв 1,387,128.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,871.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Төсвийн санхүүжилт батлагдсанаас 6.8 хувиар буурч, 1,292,396.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байгааг харгалзан төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшнийг 947.3 мянган төгрөгөөр бууруулж, 12,924.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тус байгууллага сургалт семинар, хэвлэл мэдээлэл, гадаад дотоод албан томилолтын зардал гаргахгүй байх, орон тоог бууруулах зэрэг арга хэмжээг авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн жилд сан хөмрөгийг баяжуулах, нөхөн дүүргэхэд шинээр гарсан хүүхдийн ном хэвлэл болон уншигчийн эрэлт хэрэгцээнд судалгаа хийх зэрэг мэргэжлийн ажлын талаар

тодорхой ажил тусгагдаагүй, тухайн жилд хандиваар болон худалдан авах номын бодлого чиглэл тодорхойгүй байгаа нь Номын сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т "номыг худалдан авахдаа номын татгалзал, номын борлуулалтын судалгаа болон цахим санал асуулгын дүнг үндэслэн худалдан авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн дээрх зөрчлийг арилгах талаар 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу shilendans.gov.mn цахим хуудсанд нийт 151 мэдээлэл байршуулахаас мэдээлсэн байдал 96.3 хувь, хугацаа мөрдөлт 99.4 хувийн хэрэгжилттэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, үндсэн хөрөнгө, зардлын дансдад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 89,396.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 60,523.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 5, 837.2 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах 5 акт, 3,747.8 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 50,938.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр шийдвэрийн хэрэгжилтийг завсрын аудитаар хянахад бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	5	5,837.2	5	5,837.1	100.0
Албан шаардлага	2	3,747.8	2	3,747.8	100.0
Зөвлөмж	10	50,938.1	10	50,938.1	100.0
Нийт дүн	17	60,523.1	17	60,523.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй “Acolous” програмыг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журам, санхүүгийн тайлангийн маягттай нийцүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 260,538.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 59,291.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 201,246.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Бусад хангамжийн 20,966.8 мянган төгрөгийн бараа материалыг Тусгай зориулалтын материал гэсэн ангиллаар Түүхий эд материал дансанд бүртгэсэн нь УСНББОУС 1. “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ын 15-д “Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг Зардлын эдийн засгийн ангиллаар нийт дүнгээр бус, хөтөлбөр арга хэмжээ тус бүрээр зардлын эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн, тайланг гаргахдаа 38,325.0 мянган төгрөгийн зардлыг санхүүгийн програмаас дутуу татаж, баталгаажуулан ирүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Залруулаагүй алдаа:

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд соёлын өв хөрөнгө болох номыг ялгаж тусад нь ангилаагүй нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.
- Байгууллагын ажлын байрны түрээсийн жилийн төлбөрийг тус байгууллагын төсөвт бүрэн баталж өгөөгүй, байгууллагын төсөвт батлагдсан боловч зарцуулалтын эрх нээгдээгүй зэрэг шалтгааны улмаас нийт 132,817.2 мянган төгрөгийн өр үүссэн нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн нийт 201,246.4 мянган төгрөгийн зөрчил²-ийг давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 201,246.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан боловч шинж чанарын хувьд материаллаг бус гэж үзэж, Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 1978 оноос өмнөх монгол болон орос номын тоо ширхэг, үнийн дүнг бөөн дүнгээр буюу нийт 68,429.2 мянган төгрөгөөр бүртгэсэн бөгөөд соёлын өв хөрөнгө болох номыг ялгаж тусад нь ангилаагүй байна.

Энэ нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 10-т "... орлуулах боломжгүй бөгөөд биет чанар байдал нь муудсан боловч цаг хугацааны явцад үнэ цэн нь өсдөг" хөрөнгийг соёлын өв хөрөнгө гэж тооцдог, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д "Дараах аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлнэ", 20.6.3-т "..., номын сан, ..." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Соёлын өв хөрөнгө болох үнэ цэнэ бүхий, хуучны ховор номыг ялгаж ангилан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан бүртгэлд тусгаж, хамгаалалтад авах.

2. Өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын гэрээний дагуу Нийслэлийн соёлын төв өргөөний 2300м² талбайн түрээсийн жилийн төлбөр 248,400.0 мянган төгрөгийг тус байгууллагын төсөвт бүрэн баталж өгөөгүйгээс 114,236.2 мянган төгрөг, тэтгэвэрт гарсан 2 ажилтанд дутуу олгосон тэтгэмж 13,581.0 мянган төгрөг, байгууллагын төсөвт батлагдсан боловч зарцуулалтын эрх нээгдээгүйгээс аудитын үйлчилгээний төлбөрийн 5,000.0 мянган төгрөг, нийт 132,817.2 мянган төгрөгийн өр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөвт тусгасан өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан барагдуулах, төсөвт тусгагдаагүй боловч зайлшгүй шаардлагаар үүсч буй түрээсийн төлбөрийн өр хуримтлагдах, дараагийн жилийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учруулах эрсдэлтэй байгааг дээд шатны төсөв захирагч болон холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Бусад хангамжийн бараа материалыг Тусгай зориулалтын материал гэсэн ангиллаар Түүхий эд материал дансанд бүртгэсэн.	1	20,966.8			1	20,966.8	1	20,966.8				
2	Төсвийн гүйцэтгэлийн тайланг зардлын эдийн засгийн ангиллаар нийт дүнгээр бус, дутуу илэрхийлсэн.	1	38,325.0			1	38,325.0	1	38,325.0				
	Дүн	2	59,291.8			2	59,291.8	2	59,291.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд соёлын өв хөрөнгө болох номыг ялгаж тусад нь ангилаагүй байна.	1	68,429.2					1	68,429.2
2	Ажлын байрны түрээсийн төлбөрийг төсөвт бүрэн тусгаагүй, төсөвт тусгасан зарим зардлын зарцуулалтын эрх нээгээгүйгээс өр төлбөр нэмэгдсэн.	1	132,817.2					1	132,817.2
	Дүн	2	201,246.4					2	201,246.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1.1	Номын сангийн сан хөмрөг бүрдүүлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн жилд сан хөмрөгийг баяжуулах, нөхөн дүүргэхэд шинээр гарсан хүүхдийн ном хэвлэл болон уншигчийн эрэлт хэрэгцээнд судалгаа хийх зэрэг мэргэжлийн ажлын талаар тодорхой ажил тусгаагүй, тухайн жилд хандиваар болон худалдан авах номын бодлого чиглэл тодорхойгүй байна.	1	0.00			1	0.00
	Дүн	1	0.00			1	0.00